



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2025 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

Дүрэм шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.12 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит III хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Бүх нийтийн биеийн тамир, аялал жуулчлал, спортыг хөгжүүлэх, дүүргийн хүн амын идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх, эрүүл мэндийг дэмжихэд чиглэсэн нийтийг хамарсан үйл ажиллагаа зохион байгуулах чиг үүрэг бүхий “Хайрхан хөгжлийн төв” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын нэрийг “Чингэлтэй цогцолбор” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар болгон өөрчлөн байгуулсугай.

2.Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын нэр өөрчлөгдсөнтэй холбогдуулан “Чингэлтэй цогцолбор” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын дүрмийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

3.Батлагдсан дүрмийг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу улсын бүртгэлд бүртгүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Засаг дарга (Н.Мандуул)-д даалгасугай.

4.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 73 дугаар тогтоолын хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

5.Тогтоолын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд үүрэг болгосугай.

ДАРГА



Т.УЛАМБАЯР

D:/2025-togtool

1150100019

Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурлын 2025 оны 03 дугаар сарын 28-ны  
өдрийн 10 дугаар тогтоолын хавсралт

## **“ЧИНГЭЛТЭЙ ЦОГЦОЛБОР” ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ДҮРЭМ**

### **Нэг.Нийтлэг үндэслэл**

1.1.“Чингэлтэй цогцолбор” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар нь нийслэл, дүүргээс баримтлах бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх үүрэг бүхий өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр төсвийн хөрөнгөөр санхүүжиж, ажил, үйлчилгээ эрхлэх орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар мөн.

1.2.“Чингэлтэй цогцолбор” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар /цаашид “Төсөвт үйлдвэрийн газар” гэх/ нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Хөдөлмөрийн тухай хууль, Биеийн тамир, спортын тухай хуулиуд болон Монгол Улсын бусад холбогдох хууль тогтоомж, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын захирамж, үйл ажиллагааны хөтөлбөр болон энэхүү дүрмийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна.

1.3.Энэхүү дүрмийн зорилго нь төсөвт үйлдвэрийн газрын үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг тогтоох, удирдлага, бүтэц, зохион байгуулалт, хяналт, эд хөрөнгийн эрх, түүнийг өөрчлөн байгуулах, бүртгүүлэх зэрэг бусад холбогдох харилцааг хууль зохицуулахад оршино.

1.4.Төсөвт үйлдвэрийн газрын өмчлөгч нь дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байх бөгөөд орон нутгийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэгч нь дүүргийн Засаг дарга болон эрх үүргийн дагуу дүүргийн Засаг даргын Тамгын газар байна.

### **Хоёр.Төсөвт үйлдвэрийн газрын оноосон нэр, оршин байгаа газар**

2.1.Төсөвт үйлдвэрийн газрын оноосон нэр нь “Чингэлтэй цогцолбор” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар байх ба товчилсон нэр нь “Чингэлтэй цогцолбор” ОНӨТҮГ байна.

2.2.Төсөвт үйлдвэрийн газрын оршин байгаа газар нь: Монгол улс, Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг 19 дүгээр хороо “Дээд салхит”-д байх бөгөөд дор дурдсан газрууд хамаарна. Үүнд:

2.2.1.Хайрхан хөгжлийн төв-1 (дүүргийн 19 дүгээр хороонд байрлах )

2.2.2.Хайрхан хөгжлийн төв-2 (дүүргийн 7 дугаар хороонд байрлах )

2.2.3.Хайрхан хөгжлийн төв-23 (дүүргийн 23 дугаар хороонд байрлах биеийн тамирын заал)

2.3.Үйлдвэрийн газрын шуудангийн хаяг:Монгол Улс, Улаанбаатар 13060

2.4.Веб сайт:..... ОНӨТҮГазар

2.5.Электрон шуудангийн хаяг:..... @chingeltei.gov.mn

### **Гурав.Төсөвт үйлдвэрийн газрын бэлгэдэл, тэмдэг**

3.1.Төсөвт үйлдвэрийн газар нь өөрийн бэлгэдэл, тэмдэгтэй байхаас гадна албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэнэ. Төсөвт үйлдвэрийн газрын салбар нь хэвлэмэл хуудас, тамга, тэмдэг хэрэглэж болно.

3.2.Бэлгэдэл, тэмдгийн загварыг Төсөвт үйлдвэрийн газрын даргын тушаалаар баталж, Оюуны өмчийн газарт бүртгүүлсэн байх ба түүнийг хэрэглэх эрх нь "Төсөвт үйлдвэрийн газар"-т хадгалагдана.

3.3.Тамга, тэмдгээр төсөвт үйлдвэрийн газрын албан ёсны шийдвэр, албан бичиг, гэрээ хэлцлийг баталгаажуулна.

3.4.Тамга, тэмдгийг төсөвт үйлдвэрийн газрын даргаас итгэмжлэн хариуцуулсан этгээд түшиж, ашиглалт, хамгаалалт, хадгалалтыг хариуцаж болно.

### **Дөрөв.Төсөвт үйлдвэрийн газрын үйл ажиллагааны зорилго, чиглэл, үйл ажиллагаа явуулах хугацаа**

4.1.Төсөвт үйлдвэрийн газар нь бүх нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх, дүүргийн хүн амын идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх, эрүүл мэндийг дэмжихэд чиглэсэн нийтийг хамарсан үйл ажиллагаа, стандартад нийцсэн амралт зугаалгын цогцолбор төв болгон цогцлоон бүтээх, бартаат аялал, эрүүл ахуйн шаардлага хангасан хоол, хүнс худалдаалах, автомашины зогсоолын үйл ажиллагаа, хүүхдийн тоглоомын үйл ажиллагаа арга хэмжээг зохион байгуулна.

4.2.Төсөвт үйлдвэрийн газар нь байгууллагын чадавхыг хөгжүүлэх, материаллаг баазыг бэхжүүлэх, шинэчлэх, нэмэгдүүлэх, зорилгоор хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж ажиллана.

4.3.Төсөвт үйлдвэрийн газар нь өөрийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын захирамжийг хэрэгжүүлэх, гүйцэтгэлд нь хяналт тавих ажлыг зохион байгуулна.

4.4.Төсөвт үйлдвэрийн газрын үйлчилгээ үзүүлэх, үйлчилгээний хөлс, үнэ тарифыг тухайн үеийн зах зээлийн нөхцөл байдлын судалгааг үндэслэн дүүргийн Засаг дарга батална.

4.5.Төсөвт үйлдвэрийн газар нь гадаад, дотоодын холбогдох байгууллагуудтай энэхүү дүрмийн хүрээнд харилцаа холбоо тогтоож, хамтран ажиллах, эд хөрөнгийн болоң эд хөрөнгийн бус эрх эдлэх, үүрэг хүлээх, түүнчлэн хуулийн дагуу нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдээр татагдаж болно.

4.6.Хуульд заасан эрх бүхий байгууллагын шийдвэрээр орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрыг өөрчлөн байгуулах, татан буулгахаар шийдвэрлэснээс бусад тохиолдолд төсөвт үйлдвэрийн газар нь үйл ажиллагаагаа хугацаагүй явуулна.

#### **Тав.Төсөвт үйлдвэрийн газрын эд хөрөнгийн эрх, үүрэг**

5.1.Төсөвт үйлдвэрийн газар нь өөрийн эзэмшиж байгаа эд хөрөнгийн хэмжээгээр дараах эрх эдэлж, үүрэг, хариуцлага хүлээнэ.

5.1.1.Өөрт олгогдсон үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмших, ашиглах, түрээслүүлэх;

5.1.2.Үндсэн хөрөнгийг дүүргийн Засаг даргын Тамгын газартай байгуулсан гэрээгээр олгосон эрх хэмжээний хүрээнд ашиглах;

5.1.3.Төсөвт үйлдвэрийн газрын үйл ажиллагааны үр дүнд олсон орлогыг хуульд заасан журмын дагуу дүүргийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс тухайн байгууллагын данс руу шилжүүлэх;

5.1.4.Үндсэн хөрөнгийг зөвхөн дүүргийн эд хөрөнгийн ажлын хэсгийн шийдвэрийг үндэслэн олж авах, акталж данснаас хасах, худалдан борлуулах, устгах шилжүүлэх;

5.2.Төсөвт үйлдвэрийн газар нь өөрийн өмчийн хадгалалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдлыг хариуцаж ажиллана.

#### **Зургаа.Төсөвт үйлдвэрийн газрын удирдлага**

6.1.Төсөвт үйлдвэрийн газрын зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын саналыг харгалзан дүүргийн Засаг дарга тогтоож батална.

6.2.Төсөвт үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг түүний дарга удирдана. Төсөвт үйлдвэрийн газрын даргыг /цаашид "Дарга" гэх/ дүүргийн Засаг дарга томилж, чөлөөлнө. Дарга нь дүүргийн Засаг даргатай гэрээ байгуулж ажиллана.

6.3.Дарга нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж энэхүү дүрэм болон дүүргийн Засаг даргатай байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд төсөвт үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагаа удирдан зохион байгуулна.

6.4.Дарга нь орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлд орох, тэдгээрийн захиргаанд буюу олон нийтийн болон шашны байгууллагад, сангийн удирдах ажлыг давхар хавсран гүйцэтгэхийг хориглоно.

6.5.Дарга нь төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан шалгуурыг хангасан байна.

6.6.Төсөвт үйлдвэрийн газрын дарга нь дор дурдсан эрх, үүрэгтэй байна.

6.6.1.Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд, төсөвт үйлдвэрийн газрын зорилтын санал, бизнес төлөвлөгөөг батлуулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангах;

6.6.2.Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх санхүү, төлбөрийн чадварыг бүх талаар дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явуулах;

6.6.3.Ажил үүргээ гүйцэтгэх явцад олж авсан үйл ажиллагааны болон бизнесийн нууцыг чанд хадгалах, хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглахгүй байх;

6.6.4.Дүүргийн Засаг даргаас баталсан удирдлагын бүтэц, зохион байгуулалтын хүрээнд ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг батлах, ажилтны цалингийн сангийн хүрээнд ажилд томилох , чөлөөлөх тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах;

6.6.5.Төсөвт үйлдвэрийн газрын даргыг эдлэх эрх, хүлээх хариуцлага, цалин хөлс, урамшуулал зэрэг асуудлыг үр дүнгийн гэрээнд тусгах;

6.6.6.Төсөвт үйлдвэрийн газрыг мэргэжлийн чадварлаг хүний нөөцөөр хангаж, тэднийг сургаж бэлтгэх, дадлагажуулах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх замаар байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлнэ.

6.6.7.Холбогдох хуульд заасны дагуу батлагдсан төсвийн хүрээнд санхүүг захиран зарцуулах;

6.6.8.Хөдөлмөрийн дотоод журам болон холбогдох бусад дүрэм журмыг баталж дагаж мөрдүүлэн хэрэгжилтийг хангуулна;

6.6.9.Төсөвт үйлдвэрийн газрын Хууль тогтоомж болон гэрээгээр олгосон бусад эрх үүрэг;

6.7.Төсөвт үйлдвэрийн газрын дарга нь дүүргийн Засаг дарга, эрх бүхий байгууллагаас олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулж болно.

6.8.Төсөвт үйлдвэрийн газрын дарга нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу эрх хэмжээнийхээ хүрээнд тушаал гаргана.

6.9.Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй нь ажлаас чөлөөлөх үндэслэл болно.

### **Долоо.Төсөвт үйлдвэрийн газрын хяналт**

7.1.Төсөвт үйлдвэрийн газар нь үндсэн болон салбар байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг хянах дотоод хяналт, шинжилгээ, үнэлгээ хариуцсан ажилтантай байна.

7.2.Холбогдох хууль тогтоомж, журмын дагуу төсөвт үйлдвэрийн газрын үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудитын дүгнэлт гаргуулна.

7.3.Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалт, ашиглалтад дүүргийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс хяналт тавьж ажиллана.

7.4.Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг Нягтлан бодогч хариуцан хэрэгжүүлнэ.

### **Найм.Төсөвт үйлдвэрийн газрын санхүү, бүртгэл, тайлан**

8.1.Төсөвт үйлдвэрийн газар нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомж, Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу жил бүр гаргаж, аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулна.

8.2.Төсөвт үйлдвэрийн газрын санхүүгийн тайлангийн үнэн зөвийг дарга, нягтлан бодогч хариуцна.

8.3.Төсөвт үйлдвэрийн газрын нягтлан бодогч нь бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй мэргэжлээрээ 2-оос доошгүй жил ажилласан нягтлан бодогч байх бөгөөд түүнийг дүүргийн Санхүү, төрийн сангийн хэлтэстэй зөвшилцсөний үндсэн дээр томилж, чөлөөлнө.

8.4.Төсөвт үйлдвэрийн газрын санхүүгийн жил нь тухайн оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, мөн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно.

8.5.Төсөвт үйлдвэрийн газрын орлого нь дараах санхүүгийн эх үүсвэрээс бүрдэнэ:

8.5.1.Дүүргийн төсвийн санхүүжилт

8.5.2.Ажил, үйлчилгээнээс олсон бүх орлого

8.5.3.Байгууллагатай хамтарч ажиллах гэрээний дагуу олсон үйлчилгээний орлого;

8.5.4.Хандив тусламж, зээл

8.5.5.Хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн бусад эх үүсвэр

8.6.Төсөвт үйлдвэрийн газрын санхүүгийн тайланд дараах зүйлийг тусгана:

8.6.1.Баланс

8.6.2.Үйл ажиллагааны үр дүнгийн тайлан

8.6.3.Мөнгөн гүйлгээний тайлан

8.6.4.Өмчийн өөрчлөлтийн тайлан

8.6.5.Тухайн тайлангийн хугацаанд хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчил бүхий хэлцлийн жагсаалт, нэр төрөл, үнийн дүн, удирдлагад олгосон цалин, шагнал урамшуулал;

8.6.6.Байгууллага, иргэд ажилтнаас авах авлага, тэдгээрийн үүссэн шалтгаан, барагдуулалтын явц;

8.6.7.Нэмэлт тайлбар

8.6.8.Санхүүгийн тайлангийн тодруулга;

8.6.9.Бусад;

8.7.Дарга нь дүүргийн Өмч хамгаалах зөвлөлд тухайн жилийн үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалт, зарцуулсан хөрөнгө санхүү, үр дүнгийн талаар тодорхой тусгасан тайлан илтгэх бичиг хүргүүлэх бөгөөд тайланд дараах зүйлийг тусгана.

8.7.1.Тайлангийн хугацаанд төсөвт үйлдвэрийн газрын эрхлэн явуулсан үндсэн үйл ажиллагааны талаарх танилцуулга, гарсан өөрчлөлтүүд болон эдгээр үйл ажиллагааны үр дүнгийн байдал, түүний өөрчлөлт;

8.7.2.Тайлангийн хугацаанд төсөвт үйлдвэрийн газрын албан тушаалтан, ажиллагсдад олгосон шагнал урамшил, удирдлагын зардлын хэмжээ.

### **Ёс.Төсөвт үйлдвэрийн газрын бичиг баримтыг хадгалах**

9.1.Төсөвт үйлдвэрийн газар нь дараах бичиг баримтыг хадгална.

9.1.1.Төсөвт үйлдвэрийн газрын дүрэм, дүрэмд орсон нэмэлт өөрчлөлттэй холбогдох газруудын шийдвэр, тогтоол, улсын бүртгэлийн гэрчилгээ болон бусад гэрчилгээ сертификатууд

9.1.2.Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангууд, түүнд хийгдсэн аудитын дүгнэлт, зөвлөмжүүд,

9.1.3.Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн баримтууд, түүнд тусгагдсан эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг нотлох бичиг баримтууд;

9.1.4.Үйлдвэрлэл, технологи, норм нормативууд түүнтэй холбогдох дүрэм, журам, зааврууд, бусад бичиг баримтууд;

9.1.5.Хурлын тэмдэглэл, шийдвэр, тушаал

9.1.6.Тухайн байгууллагын ирсэн, явуулсан албан бичиг

9.1.7.Нийслэлийн Архивын газрын ББНШАЗК-ын хурлаар батлагдсан газрын хөтлөх хэргийн нэрийн жагсаалт болон тухайн байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуух ач холбогдол бүхий баримт бичгүүд.

9.2.Дээрх бичиг баримтыг зохих журмын дагуу холбогдох этгээдээс хүлээн авч хадгалах, эрх бүхий этгээдэд танилцуулах архивд шилжүүлэх зэрэг ажлыг бичиг хэргийн эрхлэгч гүйцэтгэнэ.

### **Арав.Төсөвт үйлдвэрийн газрыг татан буулгах**

10.1.Төсөвт үйлдвэрийн газрыг дүүргийн Засаг даргын саналаар дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр үүсгэн байгуулах, өөрчлөх, холбогдох хуульд заасан бусад үндэслэлээр татан буулгана.

### **Арван нэг.Хариуцлага**

11.1.Монгол Улсын хууль тогтоомж, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, дүүргийн Засаг даргын захирамжийн биелэлтийг хэрэгжүүлэх явцад буруу шийдвэр гаргаж бусдад хохирол учруулсан нь шүүхээр тогтоогдсон бол уг шийдвэрийг гаргасан буруутай этгээд холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

11.2.Цогцолборын дарга нь эрх мэдлээ хэтрүүлэх буюу урвуулан ашиглаж байгууллагад хохирол учруулсан бол холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээж, хохирлыг бүрэн хариуцна.

### **Арван хоёр.Бусад**

12.1.Энэхүү дүрэмд дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор нэмэлт, өөрчлөлт, оруулж болох бөгөөд тэдгээр нь дүрмийн салшгүй нэг хэсэг болж, нэг адил хүчин чадалтай байна.

12.2.Төсөвт үйлдвэрийн газрын энэхүү дүрэм нь Монгол Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт бүртгэгдсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.